



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГА
Б.ЛХАГВАМАНДАЛ ТАНАА

2023. 03. 28 № 139

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 80.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гүн өрмийн худгийн цооног гаргах”, сумын Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 40.0 сая төгрөгийн “Газрын доройтлыг бууруулах нөхөн сэргээх”, “Доройтсон бэлчээрийн газрыг нөхөн сэргээх” ажлуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас зайлсхийж шууд худалдан авах гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1, 8.6, 8.7.1-д заасантай нийцэхгүй, нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 559.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, 7,494.7 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж холбогдох хууль, журмын дагуу бүртгэл тайланд тусгасан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

0012020277

ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АЛДАА, ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

/төгрөгөөр/

Аудитын нэр	Нийт зөрчил												Үүнээс:													
	Зөрчил			Алдаа			Нийт			Тогтоосон төлбөрийн акт			Өгсөн албан шаардлага			Өгсөн зөвлөмж			Запруулаг даагүй алдаа, зөрчлийн дүн			Хэрэгжсэн		Хэрэгжээгүй		Нийцсэн байх батламж мэдэгдэл
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	17	18	19	20	21	22								
Хамруулах	1	123,952.2			1	123,952.2			1	40,000.00	1.0	123,952.2	1	123,952.2			1.0	123,952.2			1.0	123,952.2				
Хамруулах	1	40,000.0	2	941.0	3	40,941.0			1	8,000.0			1	40,000			1.0	40,000.0			1.0	40,000.0				
Хамруулах	4	8,938.7			4	8,938.7	2	938.7	1	8,000.0	1.0	-	4	8,939			4.0	8,938.7								
Зөрчилгүй	8	43,838.6	3	17,144.1	11	60,982.7	3	6,770.9	4	37,067.7	1.0	-	8	43,839			8.0	36,267.7			8.0	7,570.9				
Хамруулах	2	80,150.0	1	20,000.0	3	100,150.0	2	23,650.2	2	80,150.0			2	80,150			2.0	80,150.0			2.0	80,150.0				
Хамруулах	2	23,650.2			2	23,650.2							2	23,650												
Хамруулах	18	320,529.7	6	38,085.1	24	358,614.8	7	31,359.8	8	165,217.7	3	123,952.2	18	320,529.7	-	36,268	18	284,262.0								
Хамруулах	18	320,529.7	6	38,085.1	24	358,614.8	7	31,359.8	8	165,217.7	3	123,952.2	18	320,529.7	-	36,268	18	284,262.0								

Аудитор
Т.Оюун-Эрлэнэ
Х.Наранцацрал

Засаг дарга:
Б.Лхагваамандал
Санхүүгийн албаны дарга:
А.Соёл-Эрлэнэ

Агаанд хянасан: Тэргүүлэх аудитор
Р.Мөнхтогтох

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газар нь аймгийн Засаг даргаас хүргүүлсэн чиглэлийн дагуу үндсэн чиг үүрэгт хамааралгүй, Дундговь аймгийн 80 жилийн үйл ажиллагаанд зориулан 20.0 сая төгрөгийг зарцуулсан зөрчил нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу тайлагналын эрсдэл өндөр үнэлэгдсэн, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилт, 118 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 113 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 91.3 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



P.МӨНХТОГТОХ

